

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

“15.9.Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 400.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгийн 10 хувиар албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.”

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн гарчгийн “төлөх” гэсний дараа “, тайлагнах” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн орлогод доор дурдсан хувиар албан татвар ногдуулна:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь
0 – 120,000,000	10 хувиар
120,000,000 – 180,000,000	12,000,000 төгрөг дээр 120 сая төгрөгөөс давсан орлогод 12 хувиар
180,000,000 – 240,000,000	19,200,000 төгрөг дээр 180 сая төгрөгөөс давсан орлогод 14 хувиар
240,000,000 – 300,000,000	27,600,000 төгрөг дээр 240 сая төгрөгөөс давсан орлогод 16 хувиар
300,000,000 – 360,000,000	37,200,000 төгрөг дээр 300 сая төгрөгөөс давсан орлогод 18 хувиар
360,000,000 ба түүнээс дээш	48,000,000 төгрөг дээр 360 сая төгрөгөөс давсан орлогод 20 хувиар

2/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон нийт 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах жилийн албан татварыг 100 хувь хөнгөлнө.”

3/23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх хэсэг:

“23.3.Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авах, барих, орон сууцны нөхцөл сайжруулахад зарцуулсан төлбөрийн баримтаар нотлогдох дараах зардалтай тэнцэх хэмжээний орлогод ногдох 15 сая төгрөг хүртэлх албан татварын хөнгөлөлтийг тухайн татвар төлөгчид нэг удаа эдлүүлнэ:

23.3.1.эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт хангасан орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө;

23.3.2.гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авсан зардал;

23.3.3.анх удаа орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан тухайн татварын жилд мөрдөх хөнгөлөлтийн хэмжээг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, хотын Зөвлөл тогтооно.”

4/26 дугаар зүйл:

“26 дугаар зүйл.Тайланг урьдчилан боловсруулж хүргүүлэх, хялбаршуулсан горимоор тайлагнах, төлөх

26.1.Татвар төлөгчийн албан татварыг тодорхойлох, ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор татварын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан боловсруулж, цахим татварын системээр татвар төлөгчид хүргүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан тайлангийн төсөлд татвар төлөгчийн татвар ногдох орлого, чөлөөлөх орлого, хасагдах зардал, татвар ногдуулах орлого, ногдуулсан, суутгуулсан, төлсөн болон төлбөл зохих албан татвар, буцаан авах боломжтой татварын хөнгөлөлтийг цахим татварын системээр тооцож, тусгана.

26.3.Энэ хуулийн 26.1-д заасан тайлангийн төслийг татварын албанаас дор дурдсан хугацаанд цахимаар хүргүүлнэ:

26.3.1.улирлын тайлангийн төслийг дараагийн улирлын эхний сард багтаан;

26.3.2.жилийн эцсийн тайлангийн төслийг дараа оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

26.4.Албан татвар төлөгч энэ хуулийн 26.3-т заасны дагуу татварын албанаас хүргүүлсэн тайланд нэмэлт мэдээлэл тусгаж, татвар ногдох орлогоос хасагдах зардал, төлбөл зохих татварын мэдээллийг залруулж болно.

26.5.Цахим төлбөрийн баримтын системд хувийн хэрэглээндээ гэж бүртгүүлсэн төлбөрийн баримт хуульд заасан шаардлага хангасан тохиолдолд татвар төлөгч үйл ажиллагааны орлогоос хасагдах зардалд шилжүүлэн бүртгүүлж тайлангаа залруулж болно. Энэ тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийн буцаан олголтыг татварын алба залруулан эцсийн тооцоо хийнэ.

26.6.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч татварын жилд гадаад улсад олсон орлого, төлбөл зохих татварын мэдээллийг энэ хуулийн 26.3.2-т заасан жилийн эцсийн тайланд тусгана.

26.7.Албан татвар төлөгч тухайн жилийн тайлангийн төслийг дараа оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хянан баталгаажуулснаар татварын тайлан тушаасанд тооцно.

26.8.Татвар төлөгч энэ хуулийн 26.7-д заасан хугацаанд тайлангийн төслийг хянаж баталгаажуулаагүй бол энэ хуулийн 23.1-д заасан татварын хөнгөлөлтийг хасаж эцсийн төлбөл зохих татварыг тооцно.

26.9.Татварын нэхэмжлэхийг татвар төлөгч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ хуулийн 26.4-т заасны дагуу тайлангаа Татварын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлд заасан хугацаанд залруулан тайлагнаж болно.

26.10.Албан татвар төлөгч нь төлбөл зохих албан татвараа дараа оны 3 дугаар улиралд багтаан төсөвт төлнө.”

5/28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг:

“28.4.Энэ хуулийн 28.3-т заасан албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан дараах хугацаанд буцаан олгоно:

28.4.1.энэ хуулийн 28.1.2-т заасан буцаан олголтыг татвар төлөгч энэ хуулийн 26.7-д заасны дагуу тайлангаа баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан;

28.4.2.энэ хуулийн 28.1.2-т зааснаас бусад буцаан олголтыг татвар төлөгч энэ хуулийн 26.7-д заасны дагуу тайлангаа баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 30 хоногт багтаан;

28.4.3.татвар төлөгч энэ хуулийн 26.7-д заасны дагуу тайлангаа хянан баталгаажуулаагүй бол илүү төлсөн албан татварыг дараа оны 3 дугаар улиралд багтаан буцаан олгоно.

4 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “эдлүүлнэ” гэснийг “эдлүүлэх бөгөөд энэ хөнгөлөлтийн хэмжээ 10 сая төгрөг хүртэл байна” гэж, 23.11 дэх хэсгийн “23.7-д” гэснийг “23.3.2-т” гэж, 25.7 дахь хэсгийн “татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг” гэснийг “татварыг” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтын “23.4-т” гэснийг “23.3-т” гэж, 28.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн” гэснийг “Албан татвар төлөгчийн баталгаажуулсан тайлангаар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “15.1,” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж,” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “энэ хуулийн 27.1, 27.2, 27.4, 27.5, 27.6-д заасны дагуу хүргүүлсэн” гэснийг, 28.5 дугаар хэсгийн “Энэ хуулийн 28.4-т заасан” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.6, 15.7, 15.8 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх хэсэг, мөн зүйлийн 21.4.1, 21.4.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалт, мөн зүйлийн 22.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.7, 23.13 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг, 27 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг